

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/18/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1. Ерөнхий зүйл	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	8
3.4. Материаллаг байдал	8
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	10
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	10
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.9. Аудитын илрүүлэлт.....	11
Залруулсан алдаа	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	11
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	11
4. Менежментийн захиадал	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13



1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 202

танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.ГАНБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 87.1 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,184,022.57	2,963,855.69
33	АВЛАГА	0.00	216,132.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		216,132.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,184,022.57	2,747,723.69
392	Биет хөрөнгө	3,184,022.57	2,747,723.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	24,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(24,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,919,989.00	2,919,989.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,013,666.55)	(1,267,065.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,829,000.00	1,829,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(551,299.88)	(734,199.80)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,184,022.57	2,963,855.69
413	Өглөг		216,132.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		216,132.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,184,022.57	2,747,723.69
51	Засгийн газрын хувь оролцоо	3,184,022.57	2,747,723.69
512	Хуримтлагдсан үр дүн	3,184,022.57	2,747,723.69
51210	Өмнөх үеийн үр дүн	3,184,022.57	3,184,022.57
51220	Тайланг үеийн үр дүн	-	(436,298.88)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,184,022.57	2,963,855.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	59,598,200.00	58,108,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	59,598,200.00	58,108,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,750,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,750,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,848,200.00	57,108,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,848,200.00	57,108,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	57,626,610.95	58,544,998.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,626,610.95	58,544,998.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,392,296.95	56,715,138.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,591,055.00	46,739,200.00
210101	Үндсэн цалин	30,921,583.00	39,795,015.00
210104	Урамшуулал	8,669,472.00	6,944,185.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,864,892.00	4,691,700.00
210201	Тэтгэврийн даатгал	2,627,292.00	3,301,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	247,500.00	278,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	309,400.00	347,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61,900.00	69,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	618,800.00	695,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,145,150.00	2,519,440.00
210401	Бичиг хэрэг	948,180.00	855,100.00
210402	Тээвэр, шатахуун	881,370.00	1,244,340.00
210404	Ном, хэвлэл	315,600.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	650,000.00	-
210604	Урсгал засвар	650,000.00	-
2107	Томилго, зочны зардал	994,000.00	450,000.00
210702	Дотоод албан томилго	994,000.00	450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	-	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,967,199.95	2,164,798.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,749,800.00	1,728,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	217,399.95	436,298.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,314.00	1,829,860.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох татаас	234,314.00	1,829,860.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	234,314.00	1,829,860.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,971,589.05	(436,298.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,971,589.05	(436,298.88)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	59,598,200.00	58,108,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	59,598,200.00	58,108,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,750,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,750,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,848,200.00	57,108,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,848,200.00	57,108,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	59,598,200.00	58,108,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,598,200.00	58,108,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,363,886.00	56,278,840.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,591,055.00	46,739,200.00
210101	Үндсэн цалин	30,921,583.00	39,795,015.00
210104	Урамшуулал	8,669,472.00	6,944,185.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,864,892.00	4,691,700.00
210201	Тэтгэврийн даатгал	2,627,292.00	3,301,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	247,500.00	278,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	309,400.00	347,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61,900.00	69,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	618,800.00	695,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,145,150.00	2,519,440.00
210401	Бичиг хэрэг	867,540.00	855,100.00
210402	Тээвэр, шатахуун	962,010.00	1,244,340.00
210404	Ном, хэвлэл	315,600.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,838,989.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,188,989.00	-
210602	Тавилга	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	650,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	994,000.00	450,000.00
210702	Дотоод албан томилолт	994,000.00	450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,749,800.00	1,728,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,749,800.00	1,728,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,314.00	1,829,860.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тагаас, санхүүжилт	234,314.00	1,829,860.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	234,314.00	1,829,860.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	3,184,022.57	3,184,022.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	3,184,022.57	3,184,022.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	3,184,022.57	3,184,022.57
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	3,184,022.57	3,184,022.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	3,184,022.57	3,184,022.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	-436,298.88	-436,298.88
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	2,747,723.69	2,747,723.69



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,501,400.00	55,278,840.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,501,400.00	55,278,840.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,501,400.00	55,278,840.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,993,400.00	46,739,200.00
210101	Үндсэн цалин	37,630,300.00	39,795,015.00
210104	Урамшуулал	9,363,100.00	6,944,185.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,691,700.00	4,691,700.00
210201	Тэтгэврийн даатгал	3,301,600.00	3,301,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	278,000.00	278,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	347,500.00	347,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	69,500.00	69,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	695,100.00	695,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,395,000.00	2,519,440.00
210401	Бичиг хэрэг	1,271,000.00	855,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,244,340.00
210404	Ном, хэвлэл	384,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,000.00	120,000.00
2107	Томилолт, зочны зардал	461,300.00	450,000.00
210702	Дотоод албан томилолт	461,300.00	450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	460,000.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	728,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	728,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,501,400.00	57,501,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,501,400.00	57,501,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	57,501,400.00	57,501,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00



3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Ганболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 09-нөөс 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 58,545.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 1,170.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 436.3 мянган төгрөгөөр буюу 14 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	216.1	216.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	3,184.0	2,747.7	-436.3
Нийт хөрөнгө	3,184.0	2,963.8	-220.2
Өр төлбөр	-	216.1	216.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,184.0	2,747.7	-436.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,184.0	2,963.8	-220.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0 төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 216.1 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэл 216.1 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 0 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,747.7 мянган төгрөг болж 436.3 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 45 тоот тогтоолоор балансаас балансад элэгдлээ бүрэн нөхсөн 24,0 сая төгрөгийн өртөгтэй Ниссан патрол 00-44 ДОР автомашиныг шилжүүлэн авсан тээврийн хэрэгслээр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 216.1 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ. Өр төлбөрийн дансны үлдэгдэл 216.1 мянган төгрөгийн ажиллагсад холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,747.7 мянган төгрөг болж 436.3 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,489.5 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна.



Нийт зардал өмнөх оноос 918.4 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардлууд байна. Энэ нь ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 57,501.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 57,501.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хэвээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 57,501.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 57,501.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 57,501.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 57,108.7 мянган төгрөгийг зарцуулж 392.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 57,108.7 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 1,0 сая төгрөгийн орлогыг авч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроон балансаас балансад шилжүүлсэн 24.0 сая төгрөгийн автомашины ИТХ-ын 2020 оны 45 дугаар тогтоолыг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.



3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24,432.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 216.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 216.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 24,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос 216.1 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн байгаа бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөгөөр бүртгээгүй байсныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 216.1 мянган төгрөгийн, мөн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 24,000.0 мянган төгрөгийн, нийт 24,216.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд

1. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос 216,1 мянган төгрөгийн татвар суутган авсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Хөрөнгийн 24,000,0 мянган төгрөгийн орлогыг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутгаан тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Үйл ажиллагааны данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 45 тоот тогтоолоор балансаас балансад элэгдлээ бүрэн нөхсөн 24,0 сая төгрөгийн өртөгтэй Ниссан патрол 00-44 ДОР автомашиныг шилжүүлэн авсан цаашид ашиглах боломжтой тээврийн хэрэгсэлд дахин үнэлгээ хийгээгүй байна.
- 1.2. Эрсдэл: Хөрөнгийн үнэ цэнэ алдагдах
- 1.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС - 17 мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/18/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хууль зөрчин цалингаас суутган авсан татварыг авлага, өр төлбөрөөр бүртгээгүй	216.1.8	Авлага, өр төлбөрөөр бүртгүүлсэн	Нягтлан бодогч	Г.Амартайван
	Ниссан патрол 00-44 ДОР автомашиныг шилжүүлэн авсан цаашид ашиглах боломжтой тээврийн хэрэгсэлд дахин үнэлгээ хийх.	24,000.0	Зөвлөмж өгөв	Нягтлан бодогч	Г.Амартайван
	Хөрөнгийн орлогыг мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй.	24,000.0	Албан шаардлага	Нягтлан бодогч	Г.Амартайван
2	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан	216.1	Албан шаардлага	Нягтлан бодогч	Г.Амартайван
ДҮН		48,432.2			